



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 11/2017

Мандалговь

Г Сайнцагаан сумын 1 дүгээр цэцэрлэгийн¹
үйл ажиллагааг хангах, зохицуулалт хийх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "г", Боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 30 дугаар зүйлийн 30.1.13, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь заалтууд, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2016 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 13-07-016/63 тоот акт, 2017 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 13-002-006/105 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын 1 дүгээр цэцэрлэгийн барилгын ашиглалтыг түр хугацаагаар зогсоосонтой холбогдуулан 2017-2018 оны хичээлийн жилийн хугацаанд тус цэцэрлэгийн үйл ажиллагааг хэвийн хангах үүднээс Сайнцагаан сумын Мандал сургуулийн хичээлийн байрны 2 дугаар давхрын баруун жигүүрт түр байрлуулан ажиллуулсугай.

Хоёр. Сайнцагаан сумын 1 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагааг стандартад нийцүүлэн шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч, хяналт тавьж ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга /Р.Мөнхтогтох/, Боловсрол, соёл, урлагийн газрын дарга /Ц.Бумангэрэл/, Мэргэжлийн хяналтын газрын боловсрол, соёлын хяналтын улсын байцаагч /Л.Ганбат/-д тус тус үүрэг болгосугай.

Гурав. Сайнцагаан сумын 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч /М.Борхүүхэн/-тэй хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулан ажиллахыг Мандал сургуулийн захирал /М.Энхбаяр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200871